



DIGITAL MUSEUM



ZEV ДИЖИТАЛ МУЗЕЙ

Zev Дижитал Музей бол Их Монгол Улсын үеийн 100 гаруй олдворыг орчин цагийн дижитал технологи ашиглан бодит мэт амьдруулсан Монголын анхны цахим музей юм. Бид энэхүү музейгээрээ дамжуулан бүх нийтийн түүхийн мэдлэгийг нэмэгдүүлэх, сонирхон судалдаг хүмүүсийг, ялангуяа залуусыг олшруулах, цаашлаад хорин нэгдүгээр зууны шинэ технологийг нийтэд хүртээмжтэй болгох зорилготой.

Музейн үзмэрийг олон нийтэд аль болох хүртээмжтэй байлгах үүднээс музейг суурин болон явуулын байдлаар дэлгэж, олон нийтэд танилцуулах боломжтой.

ZEV
DIGITAL MUSEUM
-19-

ЯАГААД ZEV МУЗЕЙ ГЭЖ?

Музей бол дэлхийн үүсэл хөгжил, хүн төрөлхтөний оршин тогтнол, ялгаатай соёл иргэншлийн бодит баримт, баталгааг олон нийтэд дэлгэн харуулах, хамгийн өндөр боловсролын ач холбогдолтой байгууламж билээ.

Гэвч одоо хэр нь дэлхийн хэмжээнд музейн үзмэр, үйлчилгээ уламжлалт хэвээр байгаа тул орчин үеийн шинэ техник технологи ашиглаж байгаа залуучуудын сонирхлыг татахгүй байгаа нь илт харагдаж байна.



Тэгвэл “Zev” дижитал музей нь орчин үеийн дэвшилтэт технологи болох VR /virtual reality/, AR /augmented reality/ зэрэг дижитал технологийг ашиглан Монголын түүх, Монгол ахуй, Монгол уламжлал, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой юм. Бид Монголын Үндэсний Музейн XIII-XIV зууны үзмэрүүдэд тулгуурлан аудио, видео, анимейшн, AR, VR гэх мэт бүхий л технологийг ашигласан интерактив тайлбартайгаар үзэгчийн харах, сонсох хүртэх мэдрэхүйгээр дамжуулан виртуал музейн орчинд зугаалах, үйл явдалд оролцох, хүссэн орон зайдаа шилжих, оюун санааны хязгааргүй орчинд зорчих боломжийг санал болгож байна.

Уг төсөл нь үндсэн үзмэрийн дөрвөн хэсгээс бүрдсэн байх юм. Үүнд:

- МОНГОЛЫН АХУЙ СОЁЛ
- ДАЙНЫ ТАКТИК БА ӨРЛӨГ ЖАНЖИД
- ИХ МОНГОЛ УЛС - ТОРГОНЫ ЗАМ
- ХАР-ХОРУМ



Бид эдгээр үзмэрүүдийг аль болох бодит болгоход дэлхийд ашиглагдаж буй бүх шинэ техник технологийг ашиглаж буй тул үзэгчдийн сонирхлыг ихээр татах нь дамжиггүй юм. Энэ нь олон нийтийг орчин цагийн шинэ технологитой танилцуулж, хорин нэгдүгээр зууны технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхахад туслах давхар ач холбогдолтой юм.

МОНГОЛЫН АХУЙ СОЁЛ

Үзэгч музейд хүрэлцэн ирж өөрийн ухаалаг утсандаа “Zev Museum” iOS болон Android аппликейшн татаж XIII зууны олдвор таниулснаар интерактив тайлбартай харьцана.

Монголын ахуй соёл харуулах хэсэгт нийт нүүдэлчин Монгол түмний эртнээс одоог хүртэл олдсон нийт 25-30 ширхэг олдвортой. Үзэгч үзмэр таниулахад 3D биетээр тухайн үеийн хэрэгслийг бодитоор тайлбарлах ба тайлбаруудыг Гильом Де Рубрук болон Жиованни Дель Планокарпини нарын “Монголчуудын түүх”, “Дорно этгээдэд зорчсон минь” номуудаас сэдэвчилсэн.





ДАЙНЫ ТАКТИК БА ӨРЛӨГ ЖАНЖИД

Уг хэсэгт Их Монгол Улсын цэргийн эдэлж хэрэглэж байсан 20-30 олдвор байх бөгөөд XIII зуунд Чингис хааны байлдааны тулаануудыг тайлбартайгаар, анимэйшн хэлбэрээр үзэж болно. Мөн Рашид Ад-Дин судрын чуулганы бүтээл энд байрлаж байна.

Чингис хаан, Хамаг Монголыг нэгтгэн Их Монгол Улсыг байгуулж, дэлхийг нэгтгэн захирч нэг сүлдэнд сөхрүүлж чадахад түүний итгэлт өрлөг жанжид ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Бид тэдний бодит дайн тулаан, зэр зэвсэг, аян дайны тактикийг археологийн 40 гаруй олдвороор баяжуулан, интерактив тайлбарын хамт шинэ технологи ашиглан бодит мэт дүрсэл, дахин бүтээсэн юм.



ИХ МОНГОЛ УЛС

Уг хэсэгт Чингис хааны үүсгэн байгуулсан Их Монгол улстай холбогдолтой түүхэн 20-30 олдвор байрласан бөгөөд хаадын хронологи, интерактив хана гэх мэт элементүүд бий.

Их Монгол Улсыг байгуулсан түүх, хууль цааз, торгоны зам, худалдаа арилжаа, харилцаа холбооны түүх, дипломат харилцаа улс төрийн бодлого зэрэг түүхийн сурвалжуудыг энд багтаасан.







ВИРТУАЛ ХАР-ХОРУМ ХОТ

Энэ хэсэгт 20 ширхэг VR төхөөрөмж байршуулсан бөгөөд музейн үзэгч ердөө төхөөрөмж зүүх төдийд Хар-Хорум хотод ирж төв гудамжаар алхан, 90м өндөр Буддын сүмийг үзэж, дотор нь орохоос гадна, олон үндэстэн зэрэгцэн амьдрах араб, хятад, төвд, орос хороололд зочлон, зах зээлийн газарт худалдаа арилжаа хийж, хотын гайхамшигт цогцолбор барилгуудыг дэргэдээс нь харж, Хааны ордны мөнгөн модноос ундрах айраг сархдыг амтлан гайхалтай виртуал орчноор дамжуулан XIII зууны Хар-Хорум нийслэлд цаг хугацаагаар аялан очих боломжтой.







zevmuseum.com

[fb/zevdigitalmuseum](https://fb.com/zevdigitalmuseum)